

# Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

**Админ** 2024-03-14 762

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

## Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

## Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;

- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/

**Материал хүлээн авах:**

- Хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 19 -ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг : Жагсаалтад бүртгэлтэй тухайн төрийн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ**

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод				Утас Цахим хаяг
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	
1	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Үйлчилгээний тасаг	Тэтгэмжийн байцаагч	1	Төрийн захиргаа	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Нягтлан бодох бүртгэл /041101/ -Санхүү /041201/ -Даатгал /041201/ -Эдийн засаг /031101/	"Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх" гэснийг хассугай. ТАЗ- 2023.03.21-ний 90 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон.	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан бол давуу тал болно.	orhon@ndaatgal.mn 99170005, 99262089

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ